"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо
"Урбанек" ХХК-ийн байр 307 тоот
Утас: 324338, 98056465,
89116465, 98006465
И-мэйл: fortune2009audit@gmail.com

2022.02.09 № 07

танай ______________-ны №______________-т

"АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО" ГҮТББ-ЫН УДИРДЛАГАД

# ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

***Зөрчилгүй дүгнэлт***

Бид **"Албан журмын даатгагчдын холбоо" ГҮТББ**-ын 2021 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон Орлогын дэлгэрэнгүй, Өмчийн өөрчлөлт, Мөнгөн гүйлгээний тайлангууд болон эдгээр тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Монгол улсын Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

***Дүгнэлтийн үндэслэл***

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн хувьд баримталсан зарчим, сонгож хэрэглэсэн арга, дотоод хяналтын системийг судлав. Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл бүхий нотолгоо олж авах зорилгоор аудитын түүврийн болон бусад арга горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.

***Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн хүлээх үүрэг хариуцлага***

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаа зөрчилгүй бэлтгэж, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, шударгаар толилуулахтай холбоотой, зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ. Засаглал хариуцсан этгээдүүд санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

***Аудиторын хүлээх үүрэг хариуцлага***

Бидний зорилго бол ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэгдсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

**ЗАХИРАЛ Ж. ОЮУНЦЭЦЭГ**

**"АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО" ГҮТББ**

## 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ
## АУДИТЛАГДСАН ТАЙЛАН ТЭНЦЭЛ

(мянган төгрөг)

| Үзүүлэлтүүд | 2021-12-31 | |
|---|---|---|
| | Аудитлагдаагүй | Аудитлагдсан |
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 709,403.3 | 709,403.3 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 25,015,324.8 | 25,015,324.8 |
| Дансны авлага | 149,291.8 | 149,291.8 |
| Найдваргүй авлагын хасагдуулга | | - |
| Бараа материал | | - |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | | - |
| Бусад эргэлтийн хөрөнгө | | - |
| ***Эргэлтийн хөрөнгийн дүн*** | ***25,874,019.9*** | ***25,874,019.9*** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 1,929,425.3 | 1,929,425.3 |
| Биет бус хөрөнгө | 240,320.2 | 240,320.2 |
| Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө | | - |
| ***Эргэлтийн бус хөрөнгийн дүн*** | ***2,169,745.5*** | ***2,169,745.5*** |
| **Нийт хөрөнгийн дүн** | **28,043,765.4** | **28,043,765.4** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ** | | |
| **Өр төлбөр** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | | - |
| Цалингийн өглөг | | - |
| Татварын өр | 272.7 | 272.7 |
| НДШ-ийн өглөг | | - |
| Богино хугацаат зээл | | - |
| Хүүгийн өглөг | | - |
| Ногдол ашгийн өглөг | | - |
| Урьдчилж орсон орлого | | - |
| Бусад богино хугацаат өр төлбөр | | - |
| ***Богино хугацаат өр төлбөрийн дүн*** | ***272.7*** | ***272.7*** |
| Урт хугацаат зээл | | - |
| Бусад урт хугацаат өр төлбөр | | - |
| ***Урт хугацаат өр төлбөрийн дүн*** | ***-*** | ***-*** |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **272.7** | **272.7** |
| **Цэвэр хөрөнгө** | | |
| Нөөц: а) хязгаарлалтгүй | 10,000.0 | 10,000.0 |
| б) хязгаарлалттай | 28,010,693.1 | 28,010,693.1 |
| Дахин үнэлгээний нөөц | | - |
| Цэвэр хөрөнгө өмчийн бусад хэсэг | 22,799.6 | 22,799.6 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | | - |
| ***Эзэмшигчийн өмчийн дүн*** | ***28,043,492.7*** | ***28,043,492.7*** |
| **Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн** | **28,043,765.4** | **28,043,765.4** |

-

**"АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО" ГҮТББ**

## 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

(мянган төгрөг)

| Үзүүлэлтүүд | 2021-12-31 | |
|---|---|---|
| | Аудитлагдаагүй | Аудитлагдсан |
| **Үндсэн үйл ажиллагааны орлого** | | |
| Гишүүдийн татвар | | |
| Хөтөлбөр, төслийн орлого | | |
| Бэлэг, хандив, тусламжийн орлого | | |
| Дуудлагын үйлчилгээний орлого | | |
| Хөрөнгө оруулалтын орлого | | - |
| Жолоочийн даатгалын сангийн эх үүсвэр | 2,970,367.1 | 2,970,367.1 |
| **Үйл ажиллагааны орлогын дүн** | **2,970,367.1** | **2,970,367.1** |
| ***Үйл ажиллагааны зардал*** | | |
| Бэлэг, хандив ба тусламж | - | - |
| (а) Байгууллагад өгсөн хандив, тусламж | | |
| (б) Хувь хүнд өгсөн хандив, тусламж | | |
| (а) Хандив, тусламж хүргэхтэй холбоотой гарсан зардал | | |
| Хөтөлбөр хэрэгжүүлсний зардал | | - |
| Төсөл хэрэгжүүлсний зардал | - | - |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 1,601,253.3 | 1,601,253.3 |
| Цалин хөлс, шагнал | 632,728.7 | 632,728.7 |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 72,312.5 | 72,312.5 |
| Засвар үйлчилгээний зардал | 22,157.9 | 22,157.9 |
| Ашиглалтын зардал | 12,509.9 | 12,509.9 |
| Түрээсийн зардал | 90,300.5 | 90,300.5 |
| Албан томилолтын зардал | 5,580.9 | 5,580.9 |
| Тээврийн зардал | 261,053.0 | 261,053.0 |
| Элэгдлийн зардал | 314,959.0 | 314,959.0 |
| Зар сурталчилгааны зардал | 93,628.8 | 93,628.8 |
| Шуудан, холбооны зардал | 39,145.8 | 39,145.8 |
| Шатахууны зардал | 8,587.1 | 8,587.1 |
| Найдваргүй авлагын зардал | | - |
| Шагнал, урамшууллын зардал | | - |
| Зээлийн хүүгийн зардал | | - |
| Бусад зардал | 48,289.2 | 48,289.2 |
| **Үйл ажиллагааны нийт зардлын дүн** | **1,601,253.3** | **1,601,253.3** |
| **Үндсэн үйл ажиллагааны үр дүн** | **1,369,113.8** | **1,369,113.8** |
| Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал) | (2,544.7) | (2,544.7) |
| Туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг (алдагдал) | (2,542.2) | (2,542.2) |
| Торгууль, хөнгөлөлтийн ашиг (алдагдал) | | - |
| Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг (алдагдал) | (2.5) | (2.5) |
| Татварын зардал | | - |
| Бусад | | - |
| **Онцгой шинжтэй зүйлс (цэвэр дүнгээр)** | - | - |
| **Тайлант үеийн цэвэр үр дүн** | **1,366,569.1** - | **1,366,569.1** |

**"АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО" ГҮТББ**

## 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(мянган төгрөг)

| Үзүүлэлт | Хязгаарлалтгүй нөөц | Хязгаарлалттай нөөц | Дахин үнэлгээний нэмэгдэл | Цэвэр хөрөнгө өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **10,000.0** | **26,642,581.8** | **-** | **25,341.8** | **-** | **26,677,923.6** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - | - |
| Залруулсан үлдэгдэл | 10,000.0 | 26,642,581.8 | | 25,341.8 | - | 26,677,923.6 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт /бууралт | | | | | | |
| Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт /бууралт | - | | | | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | | | | | | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | | | | | - |
| Тайлант үеийн цэвэр үр дүн | - | 1,368,111.3 | | (2,542.2) | | 1,365,569.1 |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **10,000.0** | **28,010,693.1** | **-** | **22,799.6** | **-** | **28,043,492.7** |

## "АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО" ГҮТББ

### 2021 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

(мянган төгрөг)

| Үзүүлэлтүүд | 2021-12-31 | |
|---|---|---|
| | Аудитлагдаагүй | Аудитлагдсан |
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| ***Мөнгөн орлогын дүн (+)*** | **805,285.4** | **805,285.4** |
| Гишүүдийн татвараас орсон мөнгө | 15,000.0 | 15,000.0 |
| Төсөл хөтөлбөрөөс хүлээн авсан мөнгө | | - |
| Бэлэг хандив тусламж | | - |
| Даатгалын сангийн орлого | 786,135.0 | 786,135.0 |
| Бусад мөнгөн орлого | 4,150.4 | 4,150.4 |
| ***Мөнгөн зарлагын дүн (-)*** | **1,354,316.8** | **1,354,316.8** |
| Ажиллагсдад олгосон мөнгө | 521,977.2 | 521,977.2 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө | 141,641.1 | 141,641.1 |
| Бараа, материал худалдан авахад төлсөн | | - |
| Ашиглалтын зардалд төлсөн | 102,810.4 | 102,810.4 |
| Шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | 30,713.9 | 30,713.9 |
| Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн бусад мөнгө | 221,219.5 | 221,219.5 |
| Хүүний төлбөрт төлсөн | | - |
| Татварын байгууллагад төлсөн | 299,172.6 | 299,172.6 |
| Даатгалын байгууллагад төлсөн | 36,782.1 | 36,782.1 |
| ***Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ*** | **(549,031.4)** | **(549,031.4)** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | - |
| Худалдсан урт хугацаат хөрөнгийн орлого | | - |
| Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө | (45,393.3) | (45,393.3) |
| Худалдсан хөрөнгө оруулалтын орлого | | - |
| Худалдаж авсан хөрөнгө оруулалт | (3,809,320.2) | (3,809,320.2) |
| ***Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн*** | **(3,854,713.5)** | **(3,854,713.5)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | - |
| Банкнаас авсан зээл | | - |
| Санхүүгийн түрээсийн өглөгийн төлбөр | - | - |
| Зээлийн төлөлт | | - |
| Төрөл бүрийн хандив | | - |
| Урт хугацаат өрийн тайлангийн хугацааны төлөлт | | |
| Төрөл бүрийн хандив | | |
| Мөнгөөр эргүүлж худалдаж авсан хувьцаа | | |
| Мөнгөөр төлсөн ногдол ашиг | | - |
| Хүү ба урамшууллын орлого | 2,324,643.5 | 2,324,643.5 |
| Валютын ханшийн зөрүү | (2.5) | (2.5) |
| ***Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн*** | **2,324,641.0** | **2,324,641.0** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **(2,079,103.9)** | **(2,079,103.9)** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,788,507.2** | **2,788,507.2** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **709,403.3** | **709,403.3** |